



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 1184

Шивээговь сум

Газар эзэмших, ашиглах эрхийн
гэрчилгээний дуудлага худалдааны
анхны үнэ тогтоо тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” 208 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/102 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Шивээговь сумын хот тосгон, бусад суурины газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг 1 дүгээр хавсралтаар, тариалангийн газрын эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг 2 дугаар хавсралтаар, сумын дуудлага худалдааны бүсийн хил заагийг харуулсан зургийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү захирамжийн хавсралтуудыг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эзэмшүүлэх, ашиглуулах газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тогтоож, үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/82 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЯГААНЦЭЦЭГ



Сумын Засаг даргын 2019 оны 6 сарын
05-ны өдрийн А/84 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт



ШИВЭЭГОВЬ СУМЫН ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗАРТ 1M²
ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

№	Сумын нэр	Үнэлгээний бүс	Анхны үнэ /эзэмших, ашиглах газрын зориулалт/ төг			
			Гэр бүлийн хамтын хэрэгцээ	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	ХАА-н үйлдвэрлэл	ХАА-гаас бусад үйлдвэрлэл
1	Шивээговь	-	560	800	480	640

Сумын Засаг даргын 2019 оны 6 сарын
5-ны өдрийн А/84 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт



ШИВЭЭГОВЬ СУМЫН ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ГАЗАР
ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА
ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

№	Сумдын нэр	Тойргийн дугаар	1 га тариалангийн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ
			Үр тариа, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн
1	Шивээговь	Г-9	37800
		Т-3	148680



Шивээговь сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 05-ны
өдрийн 784 дугаар захирамжийн
гуравдугаар хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
БУСИЙН ЗУРАГ



Таних тэмдэг



Суурин газар



Дуудлага худалдааны бус